

ОЮУНЫ ӨМЧИЙН ТУХАЙ**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь оюуны өмчийн эрхээр хамгаалагдах бүтээл, оюуны өмчийг хамгаалах зарчим, оюуны өмчийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тогтоох, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахыг дэмжихтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Оюуны өмчийн хууль тогтоомж

2.1.Оюуны өмчийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."оюуны өмч" гэж оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объект болон аж үйлдвэрийн өмчийг;

3.1.2."оюуны өмчийн мэдээллийн нэгдсэн сан" гэж нэгдсэн ангилал, индекс, стандарт, баримт бичгийн шаардлага болон хуульд заасны дагуу бүрдүүлж, боловсруулж, хадгалсан оюуны өмчийн цаасан болон цахим мэдээллийн бүрдлийг;

3.1.3."хамтын удирдлагын байгууллага" гэж зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч болон түүнд хамаарах эрх эзэмшигчид бүтээл ашиглах онцгой эрхийг хэрэгжүүлэх болон хамгаалах зорилго бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;

3.1.4."албан ёсны тогтмол хэвлэл" гэж оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцод заасны дагуу шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдгийн бүртгэлийг мэдээлэх тогтмол нийтлэлийг.

4 дүгээр зүйл.Оюуны өмчийн эрхийн хамгаалалтын зарчим

4.1.Оюуны өмчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1.хууль дээдлэх;

4.1.2.нийтийн ашиг сонирхол, зан суртахуунд нийцсэн байх;

4.1.3.оюуны өмчийн эрх эзэмшигч болон нийтийн ашиг сонирхлын тэнцвэрт байдлыг хангах;

4.1.4.оюуны өмчийн мэдээлэл нийтэд нээлттэй байх;

4.1.5.оюуны өмчийн харилцаа нь төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэл, иргэдийн хамтын ажиллагаанд тулгуурласан байх;

4.1.6.аж үйлдвэрийн өмчийн эрхийг эхэлж мэдүүлэх;

4.1.7.нэгдмэл тогтолцоо, арга зүйтэй байх.

5 дугаар зүйл.Оюуны өмчийн эрх

5.1.Оюуны өмчийн дараах эрхийг хамгаална:

5.1.1.зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх;

5.1.2.аж үйлдвэрийн өмчийн эрх.

6 дугаар зүйл.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх

6.1.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх нь тухайн бүтээлийг бодитойгоор туурвиж, бодит хэлбэрт орсон үеэс үүснэ.

6.2.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх үүсэх, түүнийг хэрэгжүүлэхэд бүртгэл шаардахгүй.

6.3.Зохиогч сайн дурын үндсэн дээр өөрийн бүтээлийн мэдээллийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны

байгууллагын зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлж болно.

6.4.Зохиогч өөрийн бүтээлийн зохиогч мөн болохоо нотлох үүрэг хүлээнэ.

6.5.Энэ хуулийн 6.3-т заасан сайн дурын бүртгэл хөтлөх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7 дугаар зүйл.Аж үйлдвэрийн өмчийн эрх

7.1.Аж үйлдвэрийн өмчийн эрхэд дараах зүйл хамаарна:

7.1.1.шинэ бүтээл;

7.1.2.ашигтай загвар;

7.1.3.бүтээгдэхүүний загвар;

7.1.4.барааны тэмдэг;

7.1.5.газар зүйн заалт.

7.2.Аж үйлдвэрийн өмчийн эрх нь оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад эрхийн хамгаалалт хийлгэж, улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

7.3.Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохих журмын дагуу энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3-т заасан зүйлийг бүртгэж патент, 7.1.4, 7.1.5-д заасан зүйлийг бүртгэж гэрчилгээ тус тус олгоно.

8 дугаар зүйл.Оюуны өмчийн эрхийг хамгаалах

8.1.Энэ хуулийн 6, 7 дугаар зүйлд заасан оюуны өмчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг тухайлсан хуулиар зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, УДИРДЛАГА, ЧИГ ҮҮРЭГ

9 дүгээр зүйл.Оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний чиг үүрэг

9.1.Энэ хуулийн 6, 7 дугаар зүйлд заасан зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх, аж үйлдвэрийн өмчийн эрхийн хэрэгжилтийг хангах, хяналт шалгалттай холбоотой асуудлаар оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.оюуны өмчийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, батлуулах;

9.1.2.аж үйлдвэрийн өмчийн эрхийн Маргаан шийдвэрлэх зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

9.1.3.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

9.1.4.хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд баримтлах журмыг батлах;

9.1.5.оюуны өмчийн шилдэг бүтээл шалгаруулах журмыг батлах;

9.1.6.лицензийн гэрээ, оюуны өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээг бүртгэх журмыг батлах;

9.1.7.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

10 дугаар зүйл.Оюуны өмчийн үндэсний зөвлөлийн чиг үүрэг

10.1.Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд Оюуны өмчийн үндэсний зөвлөл ажиллана.

10.2.Оюуны өмчийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд даргалах бөгөөд дэд дарга нь оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

10.3.Оюуны өмчийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.

10.4.Оюуны өмчийн үндэсний зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.4.1.оюуны өмчийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, салбар хоорондын уялдааг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;

10.4.2.оюуны өмчийн эдийн засгийн эргэлтийг дэмжих бодлого боловсруулж, салбар хоорондын уялдааг хангах;

10.4.3.зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх, аж үйлдвэрийн өмчийн эрхтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэх талаар санал боловсруулах.

11 дүгээр зүйл.Оюуны өмчийн байгууллага

- 11.1.Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид "оюуны өмчийн байгууллага" гэх/ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд орон нутагт хэлтэс, тасаг байгуулж, эсхүл оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулж болно.
- 11.2.Оюуны өмчийн байгууллага үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлж болох бөгөөд бусад үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
- 11.3.Оюуны өмчийн байгууллагын дэргэд аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтын талаарх өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий аж үйлдвэрийн өмчийн эрхийн маргаан шийдвэрлэх зөвлөл /цаашид "Маргаан шийдвэрлэх зөвлөл" гэх/ ажиллана.
- 11.4.Оюуны өмчийн байгууллагын дэргэд зохиогчийн эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр оюуны өмчийн байгууллагад зөвлөх, тарифыг хянан баталгаажуулах, төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөл ажиллана.
[/Энэ хэсэг т 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)
- 11.5.Оюуны өмчийн байгууллагын орон нутаг дахь хэлтэс, тасаг, оюуны өмчийн улсын байцаагч үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд тухайн шатны нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга дэмжлэг үзүүлнэ.

12 дугаар зүйл.Оюуны өмчийн байгууллагын чиг үүрэг

- 12.1.Оюуны өмчийн байгууллага дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 12.1.1.оюуны өмчийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
 - 12.1.2.оюуны өмчийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэх талаар санал боловсруулах;
 - 12.1.3.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах этгээдийг шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
 - 12.1.4.хамтын удирдлагын байгууллагад зөвшөөрөл олгох, хамтран ажиллах гэрээ байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, үр дүнг тооцож, нийтэд мэдээлэх;
 - 12.1.5.оюуны өмчийн шилдэг бүтээл шалгаруулах ажлыг энэ хуулийн 9.1.5-д заасан журмын дагуу жил бүр зохион байгуулах;
 - 12.1.6.гадаад улсын адил байгууллага болон олон улсын байгууллагатай холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах;
 - 12.1.7.оюуны өмчийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, нийтэд мэдээлэх;
 - 12.1.8.эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвараас эдийн засгийн өндөр үр ашиг өгөхүйц бүтээлийн судалгаа хийж, Оюуны өмчийн үндэсний зөвлөлийг мэдээллээр хангах;
 - 12.1.9.оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх
 - 12.1.10.эрх шилжүүлэх гэрээ, лицензийн гэрээ, франчайзийн болон мерчандайзийн гэрээг бүртгэх;
 - 12.1.11.оюуны өмчийн сургалт, судалгааны ажлыг нэгдсэн удирдамж, арга зүйгээр хангах;
 - 12.1.12.оюуны өмчтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай лавлагаа өгөх;
 - 12.1.13.оюуны өмчийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэх, гэрээ байгуулах, бүртгэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
 - 12.1.14.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг батлах;
 - 12.1.16.оюуны өмчийн эрхийг олон нийтэд сурталчлах, оюуны өмчийн эрх зүйн талаарх олон нийтийн болон оюуны өмчийн эрх эзэмшигчдийн мэдлэгийг дээшлүүлэх;
 - 12.1.15.оюуны өмчийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн сан үүсгэх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах журмыг батлах;
[Энэ заалтыг 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмсэн.](#)
 - 12.1.17.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.
[/Энэ заалтын дугаарт 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)
- 12.2.Оюуны өмчийн байгууллага зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 12.2.1.зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч, эсхүл түүнд хамаарах эрх эзэмшигчийн хүсэлтээр зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг бүртгэх, гэрчилгээ олгох, хүчингүй болгох, бүтээлийн сан бүрдүүлэх;
 - 12.2.2.зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, тэдний бүтээн туурвих үйл ажиллагааг дэмжих, ардын урлагийн бүтээлийг хамгаалах чиглэлээр иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах.